

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Цахим орчны аюул заналын судалгааны ажлын даалгавар	
Байгууллагын нэр	Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ
Хаяг	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Анкарагийн гудамж-23, Todtower, 8 давхар, 801 тоот
Холбоо барих этгээд	Захиргааны удирдлагын газрын дарга Д.Алтанчимэг
Харилцаа холбоо	Утас: 70001113 Имэйл хаяг: Contact@pubcert.mn, Altanchimeg@pubcert.mn
Хугацаа	Ажлын 15 хоног
Зорилго	Ажлын зорилго нь байгууллагын дэд бүтэц, систем, өгөгдөл мэдээлэлд учирч болзошгүй аюул занал, эмзэг байдал, эрсдэлийг тодорхойлох, үнэлэх зорилгоор кибер орчин дахь аюул заналын судалгаа хийхэд оршино
Ажлын хамрах хүрээ	Dark web форумууд, хакеруудын нийгэмлэг бүлэглэлүүд болон бусад далд эх сурвалжуудад хяналт тавьж, тэдний ашигладаг аюул заналын үзүүлэлтүүдэд (threat indicator) дүн шинжилгээ хийх.
	Аюул заналхийлэгчид, тэдгээрийн тактик, арга барил болон байгууллагад үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, дүн шинжилгээ хийх.
	Тодорхойлсон аюул занал, эмзэг байдлаас үүдэн байгууллагад учирч болох эрсдэлийг бууруулахын тулд авах арга хэмжээ, зөвлөмжийг боловсруулах.
Хүлээлгэн өгөх мэдээлэл	Кибер орчин дахь аюул занал, эмзэг байдлын судалгааны тайлан
	Сүүлийн үед хамгийн өргөн тархаж буй аюул занал, эмзэг байдлаас урьдчилан сэргийлэх зөвлөмж